

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ БОЛОН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ЖОЛООДОХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ”-ЫН ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ТӨСӨЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү журмаар төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургалт явуулах, мэргэшүүлэх, шалгалт авах, мэргэшлийн зэрэг олгох, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох, хяналт тавих, сургалтын тогтолцоотой холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү журамд ашигласан нэр томъёог Төмөр замын тээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.3 Төмөр замын тээврийн мэргэжил гэж төмөр замын тээвэрлэлт болон түүнд зориулагдсан суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, салбар зам, бусад байгууламж, тоног төхөөрөмж бүхий үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээний иж бүрдлийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, дадлын цогцыг ойлгоно.

1.4 Төмөр замын тээврийн салбарын мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, шалгалт авах, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг Төмөр замын тээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон энэхүү журмаар зохицуулна.

1.5 Төмөр замын тээврийн мэргэжлийн дээд боловсрол болон ахисан түвшний боловсрол олгохтой холбоотой харилцаа, сургалтын тогтолцоог Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хуулиар зохицуулна.

1.6 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дэргэд орон тооны бус төмөр замын тээврийн салбарын мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын салбар зөвлөл /цаашид салбар зөвлөл гэх/ ажиллана. Зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, сургалтын байгууллагыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

ХОЁР. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН СУРГАЛТ, ШАЛГАЛТ АВАХ

2.1. Төмөр замын тээврийн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг гүйцэтгэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн боловсролыг эзэмшүүлэх түвшнийг дараах байдлаар ангилна.

2.1.1. техникийн боловсрол олгох;

2.1.2. мэргэжлийн боловсрол олгох;

2.1.3. чадамжид суурилсан сургалт;

2.1.4. мэргэшүүлэх сургалт;

2.1.5. төмөр замын мэргэшлийн зэрэг олгох, ахиулах сургалт;

2.1.6. мэргэшсэн болон зөвлөх инженерийн сургалт.

- 2.2. Төмөр замын мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага нь тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий байгууллага байна.
- 2.3. Төмөр замын тээврийн байгууллагууд нь техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтыг зохион байгуулах нэгжтэй байж болно.
- 2.4. Төмөр замын тээврийн байгууллага нь гэрээний үндсэн дээр мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалт-үйлдвэрлэл, дадлага явуулах түшиц газар байна.
- 2.5. Төмөр замын тээврийн байгууллага нь эрх бүхий сургалтын байгууллагатай хамтран техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт, мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, ахиулах, сургалтыг зохион байгуулна.
- 2.6. Төмөр замын тээврийн сургалтын байгууллага нь төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, тээвэр зохион байгуулалт, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөртэй байна.
- 2.7. Төмөр замын тээврийн байгууллага нь мэргэшлийн зэрэг, албан тушаал болон цалингийн шатлал, ажиллах хугацаанд тавигдах шаардлагыг тогтоосон журмыг батлан хэрэгжүүлнэ.
- 2.8. Төмөр замын тээврийн сургалтын байгууллага нь энэхүү журмын 3.1-д заасан ангиллаар сургалт зохион байгуулахдаа боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталсан журмыг үндэслэн төмөр замын мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, зөвлөлд хянуулж, санал, дүгнэлтийг тусгасан байна.
- 2.9. Төмөр замын тээврийн байгууллага нь ажилтанд мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулж, суралцах нөхцөл, ажлын байранд тавигдах ур чадвар, чадамжийн шаардлага, ажилтны ажлын дадлага, туршлага, мэдлэг, хандлага, мэргэшлийн түвшнээр мэргэшүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журамд тусгана.
- 2.10. Төмөр замын тээврийн сургалтын байгууллага нь энэхүү журмын 3.1-д заасан ангиллын сургалтад эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн, 18 насанд хүрсэн иргэнийг сургана.
- 2.11. Төмөр замын тээврийн байгууллага, төмөр замын тээврийн сургалтын байгууллага, нэгж нь шалгалт авах, үнэлгээ өгөх үйл ажиллагааг хамтран зохион байгуулна.
- 2.12. Төмөр замын тээврийн мэргэжилтэй ажилтнаас мэдлэгийн түвшин тогтоох шалгалт, шинэ ажилтны шалгалтыг авах, үнэлгээ өгөх ажлыг мэргэжлийн шалгалтын ажлын хэсэг зохион байгуулна.
- 2.13. Мэргэжлийн шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэшсэн ажилтан, төмөр замын тээврийн байгууллагын сургалтын нэгжийн ажилтан байна.
- 2.14. Техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчдөд Боловсролын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3-т заасан боловсролын баримт бичиг олгоно.
- 2.15. Төмөр замын тээврийн байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь төгсөгчийг бүртгэж, сургалттай холбоотой мэдээллийн сан хөтөлж, Архивын тухай хуульд заасан хугацаагаар баримт бичгийг хадгална. Төмөр замын тээврийн салбар зөвлөлд холбогдох мэдээллийг хагас жил бүр хүргүүлнэ.

ГУРАВ. МЭРГЭШСЭН БОЛОН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРТ МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

- 3.1. Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерт мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлтэй /цаашид “мэргэшлийн зэрэг олгох зөвлөл” гэх/ байна.
- 3.2. Мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн бүрэлдэхүүнийг төмөр замын тээврийн байгууллагын саналыг үндэслэн, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага томилно.
- 3.3. Мэргэшлийн зэрэг олгох зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд мэргэшлийн зэрэг 9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Дарга нь Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга байна. Бүрэлдэхүүний 70-аас доошгүй хувь нь зөвлөх, мэргэшсэн, мэргэшлийн зэрэгтэй инженер байна.
- 3.4. Мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Хурлаар ажилтанд мэргэшлийн зэрэг олгох мэргэшлийн хүрээ, мэргэшлийн зэрэг горилочдод зориулсан мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, шалгалтын материал, шалгалт авах арга, мэргэшлийн зэрэг олгох, сунгах, цуцлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.5. Мэргэшлийн зэрэг олгох зөвлөлийн хурал нь 75-аас доошгүй хувийн ирцтэй хуралдаж, шийдвэрийг олонхийн саналаар гаргана. Хурлын шийдвэрийг дарга баталгаажуулна.
- 3.6. Мэргэшлийн зэрэг олгох зөвлөл нь дор дурдсан эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 3.6.1. Төмөр замын тээврийн байгууллагын мэргэшсэн болон зөвлөхийг мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг Төмөр замын тээврийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль холбогдох бусад эрх зүйн актыг үндэслэн үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.
 - 3.6.2. Төмөр замын тээврийн байгууллагын мэргэшсэн болон зөвлөх инженерийг мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг гүйцэтгэхдээ салбарын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, ур чадварын хөгжлийг дэмжин, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн, тэгш хүртээмжтэй байх зарчмыг баримтлан ашиг сонирхлын зөрчилгүй, шударга ажиллана.
 - 3.6.3. Төмөр замын тээврийн мэргэшүүлэх сургалт, мэргэшлийн зэрэг горилочдод зориулсан сургалтын багц цагт дээд боловсролын сургалтын агуулгыг багтаасан, эзэмшсэн түвшинг үнэлж, дүйцүүлэн тооцохоор тодорхойлсон байна.
 - 3.6.4. Мэргэшлийн зэрэг олгох шалгалтын комиссын бүрэлдэхүүн нь холбогдох төрийн захиргааны байгууллагын төлөөлөл болон дээд боловсролын байгууллагын мэргэшсэн ажилтан, төмөр замын тээврийн байгууллагын сургалтын нэгжийн ажилтнаас бүрдэнэ.
 - 3.6.5. Мэргэшлийн зэрэг горилочч нь мэргэжлийн алдаа, дутагдал, ёс зүйн зөрчил гаргасан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол мэргэжлийн

зөвлөлийн хурлаар мэргэшлийн зэргийг цуцлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.7. Төмөр замын тээврийн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтыг зохион байгуулах төмөр замын тээврийн байгууллага, төмөр замын сургалтын байгууллага, нэгж нь энэхүү журам, холбогдох стандартын шаардлагыг хангасан байна.

3.8. Төмөр замын тээврийн байгууллага, төмөр замын сургалтын байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.8.1. Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөр болон батлагдсан төлөвлөгөөний дагуу сургалтын нэг багц цагийн үнэлгээг тооцож, мэргэшлийн зэрэг олгох зөвлөлөөр батлуулах;

3.8.2. Сургалтын төлөвлөгөөний дагуу сургалтыг зохион байгуулах;

3.8.3. Сургалтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх;

3.8.4. Сургалтын үйл ажиллагааны тайлан мэдээ, дүгнэлт, үнэлгээг хагас жил тутамд мэргэшлийн зэрэг олгох зөвлөлд тайлагнах;

3.8.5. Сургалттай холбоотой бичиг баримт, сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, суралцагчид болон төгсөгчдийн судалгаа, шалгалтын материал, санал хүсэлтийг архивын нэгж болгон 5 жил хүртэл хугацаагаар хадгалах;

3.8.6. Төмөр замын мэргэжил олгох, дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтад олон улсын дэвшилтэд арга, технологийг нэвтрүүлэн ажиллах;

3.8.7. Төмөр замын тээврийн салбарын хөгжил, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөг боловсруулах талаар сургалтын хөтөлбөрт тусгах;

3.9. Төмөр замын тээврийн мэргэшлийн зэрэг олгох, сунгах үйл ажиллагааг зохион байгуулахдаа мэргэжил дээшлүүлэх тогтолцооны бүдүүвч, мэргэшлийн зэрэг олгох мэргэшилтэд тавигдах шаардлагын зааврыг мөрдлөг болгон ажиллана. Мэргэшлийн чиглэлээр доктор (academic)-ын мэргэшлийн зэрэг хамгаалсан тохиолдолд Зөвлөх мэргэшлийн зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэшлийн шалгалтаас чөлөөлж, судалгаа, төсөл хамгаалсны дараа олгох ба 2 удаа сунгасны дараа зэргийг хугацаагүйгээр олгоно.

3.10. Мэргэшлийн зэрэг горилох, сунгах, мэргэшлийн зэрэг ахиулах мэргэжилтэн нь журамд заасан шаардлагыг хангасан байна.

3.11. Мэргэшлийн зэрэг горилогч нь сургалт эхлэхээс 30 хоногийн өмнө дараах баримт, бичгийг бүрдүүлж, эрх бүхий сургалт зохион байгуулах байгууллагад ирүүлнэ. Үүнд:

3.11.1. Мэргэшлийн зэрэг олгох шалгаруулалтад хамрагдахыг хүссэн өргөдөл, анкет /загварын дагуу/

3.11.2. Цээж зураг /3x4 хэмжээтэй/ 2 хувь

3.11.3. Мэргэжлийн дипломын хуулбар

3.11.4. Мэргэжил дээшлүүлсэн талаарх үнэмлэх, гэрчилгээний хуулбар

3.11.5. Ажил олгогчоос гадна тухайн мэргэжлийн чиглэлээр зөвлөх, мэргэшсэн инженер, мэргэшсэн ба тэргүүлэх төсөвчин зэрэг мэргэшлийн зэрэгтэй 2-оос доошгүй мэргэжилтнээр баталгаажуулсан бүтээлийн тайлан хавсаргана. Бүтээлийн тайланг загварын дагуу хавсралтаар гаргаж, боловсруулсан норм, дүрэм, стандарт, бичсэн ном, гарын авлага, нийтлэл, бүтээлийн фото хэлбэр, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар, төсөл, судалгааг гүйцэтгэхэд боловсруулахад оролцсон баримт бичиг, төсвийн талаарх материалууд байна.

- 3.12. Зөвлөх инженер, тэргүүлэх төсөвчний зэргийг эхний удаа 5 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 5 жилээр сунгах ба зохих шалгуурыг хангасан бол 3 дахь сунгалтаас хугацаагүй олгоно.
- 3.13. Мэргэшсэн инженер, мэргэшсэн төсөвчний зэргийг эхний удаа 3 жилээр олгож, шаардлага хангасан тохиолдолд 5 жилээр сунгах ба зохих шалгуурыг хангасан бол 3 дахь сунгалтаас хугацаагүй олгоно.
- 3.14. Мэргэшлийн зэрэг олгох зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу мэргэшсэн, зөвлөх инженер, мэргэшсэн төсөвчин, тэргүүлэх төсөвчний зэргийг 1-2 жил хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно. Хэрэв мэргэжлийн зэргийг түдгэлзүүлэх хугацаа дуусгавар болсон тохиолдолд Зөвлөлд мэргэшлийн зэрэг сунгах хүсэлтээ гаргана.
- 3.15. Мэргэшлийн зэрэг цуцлуулсан, түдгэлзүүлсэн мэргэжилтэн Мэргэшлийн зэрэг олгох зөвлөлд гэрчилгээ, баталгааны тэмдгийг хураалгана.
- 3.16. Бүтээл худал мэдүүлсэн, бусдын бүтээлийг ашигласан нь тогтоогдвол мэргэшлийн зэрэг олгохоос татгалзах, олгосон зэргийг хүчингүй болгож, хураах үндэслэл болно.

ДӨРӨВ. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЖИЛТАНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

4.1 Төмөр замын тээврийн салбарын мэргэшсэн мэргэжилтэй ажилтанд энэ журмын 3.1-т заасан мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл /цаашид “мэргэшлийн зэрэг олгох зөвлөл” гэх/ мэргэшлийн зэрэг олгоно.

ТАВ. ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ

5.1. Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх гэж галт тэрэг, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүнийг жолоодож, зорчигч, ачаа тээвэрлэх эрхийг гэрчлэх баримт бичиг болно.

5.2. Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэхийг Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.

5.3. Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэхийн загварыг Төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

5.4. Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх олгоход шалгалт авна. Шалгалт 2 үе шаттай байна.

5.4.1. суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн шалгалт;

5.4.2. төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шалгалт.

5.5. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн шалгалт нь өөрийн байгууллагын онцлогт тохирсон сургалт, дадлагын үр дүнг шалгасан байна.

5.6. Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шалгалт нь төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, хөдлөх бүрэлдэхүүний онолын мэдлэгийг шалгана,

5.7. Хөдлөх бүрэлдэхүүнийг жолоодох эрхийн үнэмлэхтэй ажилтан /цаашид “машинч” гэх/-ийг төмөр замын сүлжээнд ажиллах хүрээгээр нь дараах байдлаар ангилна.

5.7.1. улсын,

5.7.2. бүсийн,

5.7.3. өөрийн суурь бүтэц, үйлдвэрийн замд,

5.7.4. салбар замд.

5.8. Машинч нь бусдын салбар зам, үйлдвэрийн зам, суурь бүтцэд нэвтрэх, дамжин өнгөрөх бол тухайн байгууллагын сургалтад хамарч, дадлага хийж, шалгалт өгч тэнцсэн байна.

5.9. Төмөр замын байгууллага нь машинч нарт мэргэшлийн зэрэг олгож болно.

5.10.Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад машинчийн шалгалт өгөхөд бүрдүүлэх баримт бичиг

5.10.1. өргөдөл, ажиллах байгууллагын хүсэлт,

5.10.2. төмөр замын зүтгүүрийн аж ахуйн мэргэжлээр их, дээд сургуулийн бакалавр, эсвэл техникчийн дипломын хуулбар;

5.10.3. эрүүл мэндийн үзлэгт /бие бялдар, хараа, өнгө ялгах, сонсгол, сэтгэл зүйн psychometric тест/ тэнцсэн хуудас

5.10.4. 21 нас хүрсэн Монгол Улсын иргэний бүртгэлийн баримт;

5.10.5. машинчийн сургалтад сурсан гэрчилгээ,

5.10.6. дадлага хийсэн байгууллагын тодорхойлолт, гэрчилгээ,

5.10.7. суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчийн шалгалтад тэнцсэн баримт,

5.10.8. туслах машинчаар 40000 км аяласан, эсвэл 3 жил ажилласан ажилласан туршлага,

5.11.Машинч бэлтгэх сургалтын агуулга, цаг

5.11.1. төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж,

5.11.2. зүтгүүрийн бүтэц, ашиглалтын заавар,

5.11.3. зүтгүүрт засвар хийх технологи,

5.11.4. автомат тоормос ашиглах заавар,

5.11.5. хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж,

5.11.6. бусад чадвар /анхаарал төвлөрүүлэх, нарийн зүйл анхаарах чадвар, тоон төхөөрөмж ашиглах чадвар/

5.11.7. боловсролын салбарын холбогдох хууль тогтоомжид нийцсэн кредит цаг.

5.12.Машинчийн үнэмлэх, жолоодлого хийх эрхийг түтгэлзүүлэх

5.12.1. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгийн хүсэлтээр,

5.12.2. Зөрчил удаа дараа гаргасан,

5.13.Машинчийн үнэмлэхийг хүчингүй болгох

5.13.1. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгийн хүсэлтээр,

5.13.2. Осол гаргасан,

5.13.3. Машинчаар 2 жил ажиллаагүй,

5.14.Хүчингүй болсон машинчийн үнэмлэхийг сэргээхгүй.

5.15.Машинчийн үнэмлэхийг дахин олгох

5.15.1. алга болгосон,

5.15.2. ашиглах боломжгүй болсон.

5.16.Мэдээллийн сан

5.16.1. Төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь машинчийн үнэмлэх авах хүсэлт, бүрдүүлсэн баримт бичиг, шалгалтын дүн, олгосон шийдвэр, үнэмлэх тэдгээртэй холбоотой баримт бичгийг цахимаар хадгалж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

4.1. Машинчийн үнэмлэх хуурамчаар үйлдсэн, ашигласан тохиолдолд Эрүүгийн хуулийн 233 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.

4.2. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль эсвэл Зөрчлийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

5.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд байгууллага, иргэн холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын
20. . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн
. . . дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

ТӨМӨР ЗАМЫН МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛТАН АЖИЛЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

Нэг. Төмөр замын тээврийн байгууллага түүний алба, тасаг, хэлтэс, салбар, нэгжийн дараах албан тушаалд төмөр замын их, дээд сургууль, коллежийн бакалаврын болон түүнээс дээш сургалтаар дээд боловсрол эзэмшсэн иргэн ажиллана. Үүнд:

- 1.1. Дарга, захирал /ТУЗ томилдогоос бусад/ Төмөр замын үндсэн мэргэжлийн алба, салбар нэгжийн орлогч дарга, орлогч захирал, ерөнхий инженер дарга, орлогч захирал, ерөнхий инженер;
- 1.2. Инженер, менежер, мэргэжилтэн /төмөр замын бүх төрлийн/;
- 1.3. Ерөнхий механикч;
- 1.4. Зааварлагч-машинч;
- 1.5. Зааварлагч /автотормозын, дулааны техникийн, вагоны үйлчлэгчийн/;
- 1.6. Дохиолол, холбооны засвар, үйлчилгээний төвийн дарга;
- 1.7. Суурь бүтэц хариуцсан инженер-механикч /дохиолол холбооны, замын/;
- 1.8. Засварын хүлээн авагч /вагон, зүтгүүрийн депогийн/;
- 1.9. Зам хэмжигч, сэв шалгагч, тосолгооны вагоны дарга;
- 1.10. Галт тэрэгний ахлах диспетчер, галт тэрэгний диспетчер / үндсэн мэргэжлийн/;
- 1.11. Техник үзлэгийн газрын дарга;
- 1.12. Засварын цехийн дарга /вагон, зүтгүүрийн депогийн/;
- 1.13. Галт тэрэгний дарга;
- 1.14. Инженер-эдийн засагч /бүх шатны нэгжийн төлөвлөгөө, санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан/;
- 1.15. Зураг төсөл судалгааны байгууллагын төмөр замын зам барилгын зураг төслийн инженер;
- 1.16. Төмөр замын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургуулийн мэргэжлийн багш;
- 1.17. Төмөр замын тодорхой чиглэлийн болон аюулгүй байдал хариуцсан хяналтын байцаагч.

Хоёр. Төмөр замын тээврийн байгууллага, түүний алба, тасаг, хэлтэс, салбар нэгжийн дараах албан тушаалд төмөр замын их дээд сургууль, түүнтэй адилтгах түвшний сургуулийн дипломын сургалтаар дээд боловсрол эзэмшсэн, бүх төрлийн техникч ажиллана. Үүнд:

- 2.1. Техникч /бүх төрлийн/;
- 2.2. Зүтгүүрийн депогийн жижүүр;
- 2.3. Зүтгүүрийн машинч;
- 2.4. Техникийн үзлэгийн хүлээн авагч-машинч;
- 2.5. Тууз орчуулагч;
- 2.6. Сэргээн босгохын болон усны галт тэрэгний дарга;
- 2.7. Мастер /үндсэн мэргэжлийн/;
- 2.8. Вагон хувиарлагч;
- 2.9. Өртөө, зөрлөгийн дарга /аж ахуйн тооцоотой бие даасан нэгжээс бусад/;

- 2.10. Өртөөний жижүүр ангигүй, I зэрэгтэй/;
- 2.11. Ачааны зохицуулагч;
- 2.12. Тооцооны төвийн эрхлэгч;
- 2.13 Тасалбар, тээшийн орлогын нярав /суурин, явуулын/;
- 2.14. Тооцооны оператор, тооцооны оператор-тасалбарын нярав;
- 2.15. Өртөөний жижүүрийн оператор;
- 2.16. Сэлгээний оператор, довын жижүүр;
- 2.17. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын механикч;
- 2.18. Сэв шалгагч, үл эвдэх шалгуурын опетаор;
- 2.19. Зам барилга, засварын машин механизмын механикч, машинч;
- 2.20. Үе угсрах газрын механикч, мастер;
- 2.21. Технологийн холбооны механикч;
- 2.22. Радио холбооны механикч;
- 2.23. Зааварлагч /үндсэн бүх мэргэжлийн/.

Гурав. Төмөр замын тээврийн байгууллага, түүний алба, тасаг, салбар нэгжийн дараах албан тушаалд мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад төмөр замын тээврийн, үйлчилгээний, үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэжлийн боловсрол эзэмшсэн иргэн ажиллана. Үүнд:

- 3.1. Зүтгүүрийн депогийн туслах жижүүр;
- 3.2. Зүтгүүрийн туслах машинч;
- 3.3. Засварчин /зүтгүүрийн болон вагоны/;
- 3.4. Вагоны үйлчлэгч;
- 3.5. Вагон үзэгч;
- 3.6. Галт тэрэгний найруулагч;
- 3.7. Өртөөний туслах жижүүр;
- 3.8. Замчин /3-аас дээш зэрэгтэй/;
- 3.9. Зам барилга, засварын машин механизмын оператор, туслах машинч;
- 3.10. Дохиолол хориглолын шугамын монтёр;
- 3.11. Билет, бараа, тээшийн тасалбар бичигч;
- 3.12. Агент;
- 3.13. Ачаа, вагон хүлээлцэгч.

Дөрөв. Төмөр замын тээврийн байгууллага, түүний алба, тасаг, хэлтэс, салбар нэгжийн дараах албан тушаалд мэргэжлийн “Чадамжийн гэрчилгээ”-тэй ажиллана. Үүнд:

- 4.1. Галт тэрэгний найруулагчийн туслах /1-3 дугаар зэрэгтэй/;
- 4.2. Замчин /1-2 дугаар зэрэгтэй/;
- 4.3. Техникийн конторчин, вагон бичигч;
- 4.4. Засварчин /зүтгүүрийн, вагоны 1-2 зэрэгтэй/;
- 4.5. Зорчигчийн вагоны үйлчлэгч
- 4.6. Монтёр /1-2 дугаар зэрэгтэй

Тав. Галт тэрэгний ба сэлгээний хөдөлгөөнд шууд холбоотой ажил албан тушаалын жагсаалт. Үүнд:

- 5.1. Төмөр замаар өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний машинч, туслах машинч;
- 5.2. Өртөөний дарга, орлогч дарга, жижүүр, туслах жижүүр;
- 5.3. Өртөөний туслах жижүүр;
- 5.4. Зөрлөгийн дарга жижүүр;
- 5.5. Зүтгүүрийн депогийн жижүүр, туслах жижүүр;

- 5.6. Диспетчер /ялгах довын, зүтгүүрийн сэлгээний, ачааны/;
- 5.7. Довын жижүүр;
- 5.8. Вагон бичигч, техникийн конторчин;
- 5.9. галт тэрэгний диспетчер, галт тэрэгний ахлах диспетчер;
- 5.10. Вагон , чингэлги йн засвар, үйлчилгээний оператор;
- 5.11. Хөдлөх бүрэлдэхүүний салгалтгүй зсварын мастер, засварчин;
- 5.12. Вагон үзэгч /ахлах/, вагон үзэгч засварчин /ахлах/;
- 5.13. Галт тэрэгний найруулагч, туслах найруулагч;
- 5.14. Дохиочин;
- 5.15. Сумчин, сум цэвэрлэгч;
- 5.16. Ивүүрчин;
- 5.17. Сэргээн босгон болон усны галт тэрэгний мастер;
- 5.18. Зорчигчийн галт тэрэгний дарга, мастер;
- 5.19. Зорчигчийн болон тусгай зориулалтын вагоны үйлчлэгч;
- 5.20. Зорчигчийн галт тэрэгний дарга, мастер;
- 5.21.Зорчигчийн болон тусгай зориулалтын вагоны үйлчлэгч;
- 5.22. Хөргүүрт вагоны мастер;
- 5.23. Замын дээд, доод бүтцийн засвар, арчилгаа болон хяналтын бригадын дарга;
- 5.24. Зам барилга, засварын машин механизмын инженер-механикч, машинч
- 5.25. Замын ахлах мастер, мастер;
- 5.26. Гүүрийн мастер;
- 5.27. Хянах, хэмжих вагон /сэв шалгагч, зам, хэмжигч/-ын тохируулагч;
- 5.28. Зам хэмжүүрийн оператор, тууз орчуулагч;
- 5.29. Сэв шалгагч, тэргэнцэрийн оператор;
- 5.30. Зам засварын чанарын хүлээн авагч;
- 5.31. Гармын жижүүр;
- 5.32. Замчин;
- 5.33. Тор засагч;
- 5.34. Дохиоллын төхөөрөмж, аппаратын засварчин, монтёр;
- 5.35.Дохиолол, төвлөрүүлэлт, хориглолын механикч;
- 5.36. Ачаа вагон хүлээлцэгч;
- 5.37. Агент;
- 5.38. Авто тоормосын зааварлагч, машинч;
- 5.39. Зам төмөр шавагч;
- 5.40. Зам төмрийн гагнуурчин;
- 5.41. Цахилгаан механик, монтёр;
- 5.42. Технологийн холбооны механикч;
- 5.43. Радио, холбооны механикч;
- 5.44. Хүлээн авах пүүлэгч.

Зургаа. Энэхүү журмын хавсралтын 4-т заасан албан тушаал, мөн гармын жижүүр, сумчин, тор засагч, сум цэвэрлэгч дохиочин зэрэг албан тушаалд мэргэжлийн бус ажилтанг дагалдуулан ажиллуулж байх хугацаанд мэргэжлийн сургалтын байгууллагын шалгалтын комисст шалгалтанд хамруулж мэргэжлийн зэрэг, чадамжийн гэрчилгээ олгож болно.